



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ИНШҮРКО ДААТГАЛ” ХХК

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Улаанбаатар хот

2025 он



“ИНШҮРКО ДААТГАЛ” ХХК-ИЙН
УДИРДЛАГАД

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2025. 5. 15 № 25/36
танай -ны №

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид “Иншүрко даатгал” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “Иншүрко даатгал” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх материаллаг зүйлсийг хамруулан үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг.

Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, /МНБ/



Ч.ГҮНДБАЯР



“ИНШҮРКО ДААТГАЛ” ХХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Бид ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгыг бүх материаллаг үзүүлэлтүүдээр СТОУС болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бэлтгэн толилуулсан болохыг үүгээр баталж байна.

Мөн санхүүгийн тайлантай холбоотой дараах үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Үүнд:

- Компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж, санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэж, толилуулах;
- Нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөтлөх;
- Тайлант хугацааны санхүүгийн тайланд компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг бүрэн бүртгэж тусгах;
- Тайланд тусгагдсан хөрөнгө, түүний эх үүсвэрийг компанийн өмчлөлд бүрэн бүртгэх ба орхигдуулахгүй байх;

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БЯМБАДОРЖИЙН СОЛОНГО



САНХҮҮ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

АЛТАЙН АНАР



**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахь хаягаар
харилцана уу:**

“СҮЛД-АУДИТ”

Хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Бага тойруу
8-р хороо, 11-р хороолол
GB center 502 тоот

Утас: 70118016

Web: www.suld-audit.mn

Захирал: Ч.Гүндбаяр

Утас: +976 9911-4056

e-mail: info@suld-audit.mn

Аудиторууд:

Ч.Гүндбаяр

Б.Долгорсүрэн

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**АУДИТЫН ДУУСГАВАР БОЛГОСОН
ТУХАЙ ТАЙЛАН**

АГУУЛГА

ХУУДАС

• Удирдлагын мэдэгдэл	2
• Хараат бус аудиторын дүгнэлт	3
• Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
• Аудитын тайлангийн тодруулга	10
• Санхүүгийн тайлангийн тодруулга	14
• Удирдлагад хүргэх захидал	22
• Менежментийн захидал, зөвлөмж	23

2025 оны 5 дугаар сарын 15

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.1	Бэлэн мөнгө	100,000.00	150,280,000.00
1.1.2	Харилцахад байгаа мөнгө		60,754,034.92
1.1.3	Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	100,000.00	211,034,034.92
1.2	Даатгалын авлага		
1.2.1	Даатгалын хураамжийн авлага		79,740,220.00
1.2.2	Буруутай этгээдээс авах авлага		
1.2.3	Давхар даатгалаас авах авлага		
	Даатгалын авлагын дүн		79,740,220.00
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.3.1	Бусад авлага		118,739.32
	Бусад санхүүгийн хөрөнгийн нийт дүн		118,739.32
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө		
1.4.1	НДШ-ийн авлага, бусад татварын авлага		
1.4.2	ААНОАТатварын авлага		
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө		76,223,237.47
1.4.4	Бараа материал		34,057,500.00
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		146,902,528.70
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө		
	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн		257,183,266.17
1.5	Хөрөнгө оруулалт		
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат		5,051,240,004.06
1.5.2	Үнэт цаас		
	Хөрөнгө орлуулалтын дүн		5,051,240,004.06
1.6	Даатгалын хөрөнгө		
1.6.1	Хойшлогдсон давхар даатгалын хураамж		
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг		
1.6.3	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэл		
	Даатгалын хөрөнгийн дүн		
1.7	Үндсэн хөрөнгө/Цэвэр/		34,974,857.88
1.8	Биет бус хөрөнгө/Цэвэр/		14,116,666.64
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	100,000.00	5,648,407,788.99
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Даатгалын өглөг		
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг		
2.1.1.3	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг		4,794,688.85
	Даатгалын өглөгийн дүн		4,794,688.85
2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр		
2.1.2.6	Бусад өр төлбөр		48,164,605.00

	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн		48,164,605.00
2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр		
2.1.3.1	Цалингийн өглөг		46,285.72
2.2.3.2	НДШ-ийн өглөг		12,695,961.59
2.1.3.3	ААНОАТатварын өглөг		
2.1.3.4	Хойшлогдсон татварын өглөг		
2.1.3.5	Урьдчилж орсон орлого		
2.1.3.6	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр		
2.1.3.11	Бусад санхүүгийн бус өр төлбөр		22,975,894.65
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн		35,718,141.96
2.1.4	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц		313,277,943.45
2.1.5	Хоёрдогч өглөг, хүү		
2.1.6	Нөхөн төлбөрийн нөөц сан		
2.1.6.1	Учирсан боловч мэдэгдээгүй ХНС		67,064,304.32
2.1.6.2	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан		662,500.00
2.1.6.3	Учирч болзошгүй хохирлын нөөц сан		90,084,783.73
2.1.6.4	Тусгай нөөц сан		
	Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн		157,811,588.05
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		559,766,967.31
2.2	ЭЗДИЙН ӨМЧ		
2.2.1	Эздийн өмч	100,000.00	5,000,000,000.00
2.2.2	Эздийн өмчийн бусад хэсэг		197,000,000.00
2.2.3	Хуримтлагдсан ашиг/алдагдал		(108,359,178.32)
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	100,000.00	5,088,640,821.68
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	100,000.00	5,648,407,788.99

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно/

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
2024 ОНЫ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

		(төгрөгөөр)	
№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Даатгалын үйл ажиллагаа		
2	Даатгалын хураамжийн нийт орлого		472,939,269.06
3	Даатгалын хураамжийн буцаалт		(1,849,837.43)
4	Давхар даатгалын хураамжийн зардал		
5	Даатгалын хураамжийн цэвэр орлого		471,089,431.63
6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт		(313,277,943.45)
7	Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт		
8	Орлогод тооцсон хураамж		157,811,488.18
9	Нийт нөхөн төлбөр		1,053,200.00
10	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр		
11	Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр		
12	Нөхөн төлбөрийн цэвэр зардал		1,053,200.00
13	Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт		67,726,804.32
14	Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт		
15	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт		90,084,783.73
16	Зардалд тооцсон нөхөн төлбөр		158,864,788.05
17	Даатгалын гэрээний зардал		119,577,284.77
18	Давхар даатгалын шимтгэлийн орлого		
19	Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)		(120,630,584.64)
20	Хүү, Эрхийн шимтгэлийн орлого		666,375,536.07
21	Бусад орлого		
23	Ерөнхий ба удирдлагын зардал		628,755,257.69
24	Борлуулалт, маркетингийн зардал		
25	Санхүүгийн зардал		196,100.00
26	Бусад зардал		34,738,455.96
27	Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз		
28	Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз		
29	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(117,944,862.19)
30	Орлогын албан татварын зардал		(9,585,683.87)
31	Татварын дараах ашиг (алдагдал)		(108,359,178.32)
32	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг(алдагдал)		
33	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(108,359,178.32)
34	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
35	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
36	Бусад		
37	Орлогын нийт дүн		(108,359,178.32)
38	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно/

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
2024 ОНЫ ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	НТК	Тогтвортой байдлын сан	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	100,000.00					100,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-			100,000.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(108,359,178.32)	(108,359,178.32)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						
6	Өмчид гарсан өөрчлөлт	4,999,900,000.00			197,000,000.00		5,196,900,000.00
7	Зарласан ногдол ашиг						
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000,000,000.00			197,000,000.00	(108,359,178.32)	5,088,640,821.68

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно/

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН 2024 ОНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		391,349,211.63
1.1.1	Даатгалын хураамжийн орлого		391,349,211.63
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		894,682,907.30
1.2.1	Ажиллагчдад төлсөн		315,475,684.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		87,692,127.68
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн		116,355,943.77
1.2.4	Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		
1.2.5	Нөхөн төлбөрт төлсөн		1,053,200.00
1.2.5.1	Үүнээс: Сайн дурын даатгалын		1,053,200.00
1.2.5.2	Албан журмын даатгалын		
1.2.6	Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		46,475,607.14
1.2.7	Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр		73,101,677.63
1.2.8	Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр		
1.2.9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		190,000.00
1.2.10	Татварын байгууллагад төлсөн		79,166,020.04
1.2.11	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.12	Бусад мөнгөн зарлага		175,172,646.19
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(503,333,695.67)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		6,306,398,763.81
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		5,640,023,227.74
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		666,375,536.07
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		10,789,031,033.22
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		23,835,360.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд		18,150,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		10,747,045,673.22
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(4,482,632,269.41)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		5,196,900,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас		4,999,900,000.00
3.1.4	Бусад		197,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		5,196,900,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		210,934,034.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		100,000.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		211,034,034.92

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салиггүй хэсэг болно/

АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Иншүрко даатгал ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийсэн тодруулга тэмдэглэл

1. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын мэдээлэл / Оноосон нэр /	Монгол	Иншүрко даатгал ХХК
Албан хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Эко интернэйшнл тауэр, 22-р давхар, 2205 тоот	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	9011857876	
Регистрийн дугаар	8437882	
Бүртгэгдсэн он сар /Байгуулагдсан огноо /	2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр	
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	ТЗ201/24	
Хувьцаа эзэмшигчид	Наваансамдан овогтой Ганбямба	
Даатгалын салбар	Салбар нэгжгүй	
Даатгалын бүтээгдэхүүн	Сайн дурын болон албан журмын даатгал	
Давхар даатгал	Үндэсний давхар даатгагч Mongolian Re	
ТУЗөвлөл	5	
Гүйцэтгэх удирдлага	Б.Солонго	
Санхүү, удирдлагын газрын дарга	А.Анар	
Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрөлд заагдсан ердийн даатгалын 12 төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	
Актуарч	О.Нарангэрэл	
Боловсон хүчний тоо	Тайлант онд 16 ажилтантай ажилласан.	
Санхүүгийн тайлангийн аудит	Сүлд-Аудит ХХК	

2. АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Сүлд-Аудит ХХК ба Иншүрко даатгал ХХК-ийн хооронд 2024 оны 11 дүгээр сарын 20-нд хийсэн Аудитын ажил гүйцэтгэх гэрээний дагуу бид танай байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний аудитын зорилго нь Иншүрко даатгал ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журам, зааврын дагуу үнэн зөв бэлтгэгдсэн гэдгийг батлахад оршино. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан бөгөөд аудитын ажлын баримтууддаа үндэслэн дүгнэлт гаргасан болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТУХАЙ

Иншүрко даатгал ХХК нь Санхүүгийн тайлан балансаа “Ultimate ERP” програмыг ашиглан Сангийн сайдын 2020 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу бэлтгэн тайлагнасан байна. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдийг Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлсэн байна.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

А) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгөө *Касс дахь бэлэн мөнгө* (төгрөгийн) ба *Банкны харилцах данс* (төгрөгийн) гэж ангилан бүртгэдэг.

Б) Даатгалын авлага

Даатгалын хураамжийн авлагыг даатгалын гэрээ байгуулагдаж даатгалын хураамжийг орлогод хүлээн зөвшөөрөх үед бүртгэнэ.

Буруутай этгээдээс авах авлагыг буруутай этгээдээс авах нөхөн төлбөрийн орлогыг хүлээн зөвшөөрөх үед бүртгэнэ.

Давхар даатгагчаас авах нөхөн төлбөрийн авлагыг нөхөн төлбөрийн зардлыг хүлээн зөвшөөрөх үед бүртгэнэ. Давхар даатгалын гэрээг үндэслэн нөхөн төлбөрийн давхар даатгагчид ногдох хэсгийг давхар даатгагчаас авах нөхөн төлбөрийн авлагаар хүлээн зөвшөөрнө.

Давхар даатгагчаас авах хураамжийн авлагыг давхар даатгалын гэрээ цуцлагдах үед хүлээн зөвшөөрнө.

Давхар даатгагчаас авах шимтгэлийн авлагыг давхар даатгалын гэрээ байгуулагдснаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

В) Санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө

НББОУС 1 болон Сангийн сайдын 2020 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу санхүүгийн тайланд санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийг салгаж харуулдаг.

Г) Бараа материал

Бараа материал нь хангамжийн материалаас бүрддэг. Материалыг зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг ашигладаг. Хуучирч муудсан, хугацаа хэтэрсэн материал байхгүй.

Д) Хөрөнгө оруулалт

Хадгаламж, хадгаламжийн сертификат /3 сараас дээш/-аарх хөрөнгө оруулалтад дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат, мөн тэдгээрт хуримтлуулж тооцсон хүүний авлагыг хамруулан тайлагнадаг. Мөн Засгийн газрын өрийн хэрэгсэл, Төв банкны үнэт цаас, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Орон нутгийн гаргасан өрийн бичиг, Компанийн бонд, Хөрөнгийн биржийн I ба II ангиллын хувьцаа, Вексель, Хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас /нэгж эрх/, гадаадын үнэт цаас зэрэг хамаарна. Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын зорилгыг харгалзан "Арилжааны буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх", "Хугацааны эцэс хүртэл эзэмших", "Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас" "Борлуулахад бэлэн" гэж 4 ангилна.

Е) Даатгалын хөрөнгө

Даатгалын хөрөнгөд давхар даатгалын хойшлогдсон хураамж, Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг, Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал хамаардаг.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдэл нь давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцсон дүн байна.

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр УБМХНС болон МБТХНСангийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр бүртгэнэ.

Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардлыг даатгалын гэрээнд заасан даатгалын орлогын шимтгэлийн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Ё) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны худалдан авалтын өртгөөр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог ба ашиглалтын хугацаа нь:

Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, тоног төхөөрөмж	2 жил

Ж) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анх удаад нь өртгөөр хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын хугацаанд хорогдуулдаг бөгөөд ашиглалтын хугацаа нь:

Программ хангамж	3 жил
------------------	-------

З) Өр төлбөр

Бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон татвар, нийгмийн даатгалын шимтгэл, даатгалын хураамжийн буцаалт, нөхөн төлбөрийн өглөг, даатгалын гэрээний шимтгэлийн өглөгийг тооцон бүртгэдэг. Өр төлбөрийг үүссэн үеийн нэрлэсэн үнээр бүртгэдэг.

И) Эздийн өмч

Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө нь компанийн бүх өр төлбөрийг барагдуулсаны дараа үлдэх хөрөнгө юм.

Й) Даатгалын орлого

Даатгалын хураамжийн орлогыг даатгалын гэрээний дагуу даатгалын хураамжийг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй даатгалын хураамжийн бодит үнэ цэнээр бүртгэнэ.

Давхар даатгалын шимтгэлийн орлогыг хойшлогдсон давхар шимтгэлийн орлогоос хувь тэнцүүлэн тооцсон дүнгээр бүртгэнэ. Хэрэв тухайн даатгал нь давхар даатгалд даатгуулсан (Cut through clause) буюу давхар даатгагч даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид шууд олгохоор зааж Даатгалын компанийг нөхөн төлбөрийн үүргээс бүрэн чөлөөлж, түүний үүргийг Давхар даатгагч өөртөө шилжүүлэн авсан бол хойшлогдсон давхар шимтгэлийн орлогоос хувь тэнцүүлэн тооцсон дүнгээр бүртгэнэ. Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийг давхар даатгагчийн олгохоор шийдвэрлэсэн дүнгээр, хэрэв давхар даатгагчаас хохирлыг барагдуулахаар шийдвэрлээгүй боловч нөхөн төлбөрийг урьдчилж төлсөн бөгөөд уг төлбөрийг буцаах магадлалгүй бол уг төлбөрийн хэмжээгээр бүртгэнэ.

Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрийг буруутай этгээдийн төлсөн эсвэл буруутай этгээдээр төлүүлэх дүнгийн бодит үнэ цэнээр бүртгэнэ.

Хөрөнгө оруулалтын орлогыг хүлээн авсан эсвэл үүссэн авлага болон орлогын бодит үнэ цэнээр бүртгэнэ.

К) Даатгалын зардал

Зардлыг төлсөн мөнгө эсвэл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

Давхар даатгалын хураамжийн зардлыг давхар даатгалын гэрээний хураамжийн нийт дүнгээр бүртгэнэ.

Даатгалын хураамжийн буцаалтыг даатгалын гэрээнд заасны дагуу тооцоолсон даатгагчаас даатгуулагчид төлөх даатгалын хураамжийн буцаалтын дүнгээр бүртгэнэ.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тайлагналын өдрөөрх ОТХНөөцийн үлдэгдлээс өмнөх тайлагналын өдрийн ОТХНөөцийн эцсийн үлдэгдлийг хасаж тодорхойлно. Энэхүү ялгавар нь эерэг утгатай бол ОТХНөөцийн өсөлт, сөрөг утгатай бол ОТХНөөцийн бууралт болно.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлтийг тайлагналын өдрөөрх Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлээс өмнөх тайлагналын өдрийн Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн эцсийн үлдэгдлийг хасаж тодорхойлно. Энэхүү ялгавар нь эерэг утгатай бол Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өсөлт, сөрөг утгатай бол Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн бууралт болно.

Нөхөн төлбөрийн зардлыг даатгагчийн төлсөн дүнгээр бүртгэнэ. Даатгалын нөхөн төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр олгосон бол тухайн зүйлийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Хэрэв даатгагч нөхөн төлбөрийг барагдуулах явцад даатгалын зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлж авсан бол хохирлыг барагдуулахаар олгож буй нөхөн төлбөрөөс шилжүүлэн авсан даатгалын зүйлийн бодит үнэ цэнийг хассан дүнгээр нөхөн төлбөрийн зардлыг бүртгэх ба тухайн шилжүүлэн авсан даатгалын зүйлийг бодит үнэ цэнээр өмчлөх бусад хөрөнгөнд бүртгэнэ.

Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийг тайлагналын өдрөөрх УБМХНС болон МБТХНСангийн үлдэгдлээс өмнөх тайлагналын өдрийн УБМХНС болон МБТХНСангийн эцсийн үлдэгдлийг хасаж тодорхойлно. Энэхүү ялгавар нь эерэг утгатай бол УБМХНС болон МБТХНСангийн өсөлт, сөрөг утгатай бол УБМХНС болон МБТХНСангийн бууралт болно.

Даатгалын нөөцийн Давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлтийг санхүүгийн тайлагналын өдрөөр хүлээн зөвшөөрнө.

УБМХНСангийн өөрчлөлтийг тайлагналын өдрөөр СЗХ-ны журмын дагуу актуарч тооцоолсон дүнгээр бүртгэнэ.

Даатгалын гэрээний зардлыг даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардлаас тайлант хугацаанд ногдох хэсгийг бүртгэнэ.

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. МӨНГӨН ХӨРӨНГӨ

			/мянган төгрөг/	
Дансны нэр	Дансны дугаар	Валют	2023.12.31	2024.12.31
Касс		MNT	100.0	150,280.0
Бэлэн мөнгөний дүн			100.0	150,280.0
Харилцах – Төрийн банк	107501860595	MNT		11,626.6
Харилцах – Төрийн банк	107501863002	MNT		0.0
Харилцах – Төрийн банк	107501863001	MNT		1,606.4
Харилцах – Төрийн банк	107501863000	MNT		1.0
Харилцах – Төрийн банк	342200820552	MNT		22.3
Харилцах - ХХБанк	432087935	MNT		15.0
Харилцах – Хас банк	7212	MNT		19.5
Харилцах – Капитрон банк	3030012650	MNT		2,605.0
Харилцах - Хаан банк	5112459927	MNT		18.1
Харилцах - Хаан банк	5112466195	MNT		18.8
Харилцах - ТХБ	9000080133	MNT		23.3
Харилцах - ТХБ	9000080135	MNT		0.0
Харилцах - ТХБ	9000080655	MNT		17,514.1

Харилцах - ТХБ	9000086839	MNT	27,284.0
Бэлэн бус мөнгөний дүн		0.0	60,754.0
Мөнгөн хөрөнгө нийт дүн		100.0	211,034.0

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр эдгээр дансдын санхүүгийн бүртгэл дэхь үлдэгдэл нь байршиж буй банкуудаас авсан дансны гүйлгээ үлдэгдлийн баталгаа болон бэлэн мөнгөний тооллогын үлдэгдлийн дүнтэй тохирч байна.

ТОДРУУЛГА 2. ДААТГАЛЫН АВЛАГА

		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Даатгалын хураамжийн авлага-Гэнэтийн осол, эмчилгээ		4,512.3	
Даатгалын хураамжийн авлага - Хөрөнгийн даатгал		15,835.2	
Даатгалын хураамжийн авлага -Авто тээврийн хэрэгслийн		27,642.7	
Даатгалын хураамжийн авлага- Хариуцлагын даатгал		16,000.0	
Даатгалын хураамжийн авлага- Ачааны даатгал		15,750.0	
Нийт дүн		79,740.2	

ТОДРУУЛГА 3. БУСАД АВЛАГА

		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Бусад авлага	-	118.7	
Нийт дүн	0.0	118.7	

Бусад авлагын дансанд ажилчдаас авах цалингийн авлагыг бүртгэсэн байна.

ТОДРУУЛГА 4. БАРАА МАТЕРИАЛ

		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	2023.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2024.12.31
Хангамжийн материал	0.0	34,057.5		34,057.5
Нийт дүн	0.0	34,057.5		34,057.5

ТОДРУУЛГА 4. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ

		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	2023.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2024.12.31
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	76,223.2		76,223.2
Нийт дүн	0.0	76,223.2		76,223.2

Алдагдал шилжүүлэлттэй холбоотойгоор хойшлуулсан татварын зардлыг тус дансанд бүртгэсэн байна.

ТОДРУУЛГА 5. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ ТООЦОО

		/мянган төгрөг/
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Урьдчилж төлсөн тооцоо		117,384.7
Урьдчилж гарсан зардал		29,517.8
Нийт дүн	0.0	146,902.5

ТОДРУУЛГА 6. ДҮРМИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ

		/мянган төгрөг/
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж – Төрийн банк		1,000,000.3
Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж – Төрийн банк		50,000.0
Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж – Тээвэр хөгжлийн банк		1,801,239.7
Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж - Хаан банк		1,500,000.0
Дүн	0.0	4,351,240.00
Санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хөрөнгө оруулалт- Омни капитал ББСБ итгэлцэл		700,000.0
Дүн		700,000.0
НИЙТ ДҮН	0.0	5,051,240.0

ТОДРУУЛГА 10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

				(мянган төгрөг)
Үзүүлэлт	2023.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2024.12.31
Тавилга эд хогшил		13,734.0		13,734.0
Компьютер, бусад хэрэгсэл		26,170.8		26,170.8
Үндсэн хөрөнгийн дүн	0.0	39,904.8		39,904.8
Хуримтлагдсан элэгдэл				
Тавилга эд хогшил		1,094.8		1,094.8
Компьютер, бусад хэрэгсэл		3,835.1		3,835.1
Хуримтлагдсан элэгдлийн дүн	0.0	4,929.9		4,929.9
Үндсэн хөрөнгө /цэвэр дүн/	0.0	34,974.8		34,974.8

Тайлант хугацаанд 39,904.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

ТОДРУУЛГА 11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

		/мянган төгрөг/
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31

Бие бус хөрөнгө		18,150.0
Программ хангамж хасагдуулга		(4,033.3)
Нийт дүн	0.0	14,116.7

Биет бус хөрөнгийн дансанд санхүүгийн программ хангамжийг бүртгэсэн байна

ТОДРУУЛГА 12. ДААТГАЛЫН ӨГЛӨГ

	/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг		4,794.7
Нийт дүн	0.0	4,794.7

Даатгалын гэрээний даатгалын зуучлагчид өгөх шимтгэлийн өглөгийн үлдэгдэл.

ТОДРУУЛГА 13. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

	/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
ХХОАТ-ын өглөг		22,975.9
Татварын дүн	0.0	22,975.9
НДШ-ийн өглөг		12,696.0
Нийт дүн	0.0	35,671.9

ТОДРУУЛГА 14. БУСАД ӨГЛӨГ

	/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Цалингийн өглөг		46.3
Бусад өглөг		48,164.6
Нийт дүн	0.0	48,210.9

Бусад өглөгийн дансанд хувь нийлүүлэгчид төлөх өглөг болон бэлтгэн нийлүүлэгчид төлөх өглөгийн тооцоо тусгагдсан байна.

ТОДРУУЛГА 15. ОРЛОГО ТООЦООГҮЙ ХУРААМЖИЙН НӨӨЦ

	/мянган төгрөг/			
Үзүүлэлт	2023.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2024.12.31
ГО-ын даатгал		62,412.9	27,373.0	35,040.0
Хөрөнгийн даатгал		178,094.3	54,392.8	123,701.4
АТХ-ийн даатгал		76,638.7	21,015.7	55,623.0
Ачааны даатгал		37,500.0	13,553.4	23,946.6
Барилга угсралтын даатгал		16,000.0	5,216.4	10,783.6
Хариуцлагын даатгал		3,939.9	1,214.3	2,725.6
Зээлийн даатгал		97,121.5	35,663.7	61,457.8

Нийт дүн	471,707.3	158,429.3	313,277.9
-----------------	------------------	------------------	------------------

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн үлдэгдэл нь даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ тус бүрийн хувьд даатгалын хураамжийг хувь тэнцүүлэх аргаар гэрээний үлдэх хугацаанд тооцсон дүн байна.

ТОДРУУЛГА 16. УЧИРСАН БОЛОВЧ МЭДЭГДЭЭГҮЙ ХОХИРЛЫН НӨӨЦ

	/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал		5,640.9
Хөрөнгийн даатгалын		9,152.9
Авто тээврийн хэрэгслэлийн		13,659.8
Ачаа тээврийн даатгалын		10,269.9
Барилга угсралтын даатгалын		4,465.1
Хариуцлагын даатгалын		185.8
Зээлийн даатгалын		23,690.1
Нийт дүн	0.0	67,064.3

ТОДРУУЛГА 17. МЭДСЭН БОЛОВЧ ТӨЛӨӨГҮЙ ХОХИРЛЫН НӨӨЦ

	/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Хөрөнгийн даатгалын		500.0
Авто тээврийн хэрэгслэлийн		162.5
Нийт дүн	0.0	662.5

Тайлант онд нэхэмжилсэн хохиролын нөөц сан 662.5 мянган төгрөгөөр үүсгэсэн байна.

ТОДРУУЛГА 18. УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ХОХИРЛЫН НӨӨЦ

	/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Гэнэтийн осол, эмчилгээ		21,446.6
Хөрөнгө		44,501.0
Авто тээврийн хэрэгсэл		7,193.4
Ачаа тээвэр		3,283.6
Барилга угсралт		751.4
Хариуцлага		1,028.5
Зээл		11,880.3
Нийт дүн	0.0	90,084.8

ТОДРУУЛГА 19. ЭЗДИЙН ӨМЧ

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Эздийн өмч	100.0	5,000,000.0
Эздийн өмчийн бусад хэсэг		197,000.0
Хуримтлагдсан ашиг		(108,359.2)
Нийт дүн	100.0	5,088,640.8

ТОДРУУЛГА 20. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ОРЛОГО

/мянган төгрөг/		
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Даатгалын хураамжийн нийт орлого		472,939.3
Үүнээс Даатгалын хураамжийн буцаалт		1,849.8
Даатгалын хураамжийн цэвэр орлого	0.0	471,089.5

Тайлант хугацаанд 471,089.5 мянган төгрөгийн даатгалын гэрээний цэвэр орлоготой ажилласан байна.

ТОДРУУЛГА 21. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЗАРДАЛ

/мянган төгрөг/		
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Даатгалын гэрээний зардал	0.0	119,577.3
Үүнээс Даатгалын зуучлагчийн шимтгэл		73,101.7
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		46,475.6

Тайлант хугацаанд даатгалын гэрээний 119,577.3 мянган төгрөгийн зардал гарсан байна.

ТОДРУУЛГА 22. БУСАД ОРЛОГО

/мянган төгрөг/		
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		666,375.5
Нийт дүн	0.0	666,375.5

ТОДРУУЛГА 23. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГА, МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

/мянган төгрөг/			
№	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	Цалингийн зардал	407,171.5	64.8
2	НДШ-ийн зардал	50,793.6	8.1
3	Албан татвар, хураамжийн зардал	10,475.0	1.7
4	Бичиг хэргийн зардал	3,862.9	0.6
5	Шуудан холбооны зардал	3,922.2	0.6
6	Мэргэжлийн үйлчилгээний зардал	9,735.7	1.5
7	Сонин сэтгүүл захиалгын зардал	603.4	0.1
8	Даатгалын зардал	233.2	1.4

9	Түрээсийн зардал	116,697.4	18.6	
10	Шатахууны зардал	190.0	0.0	
11	Элэгдлийн зардал	8,963.2	1.4	
12	Хүлээн авалтын зардал	10,326.0	1.6	
13	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	4,894.1	0.8	
14	Зар сурталчилгааны зардал	887.0	0.1	
Нийт дүн		0.0	628,755.3	100.0

Тайлант хугацаанд нийт 628,755.3 мянган төгрөгийн зардал гарсан ба үүнээс ажилчдын цалингийн зардал 64.8 хувь, түрээсийн зардал 18.6 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 8.1 хувийг эзэлж байна.

ТОДРУУЛГА 24. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Санхүүгийн зардал		196.1	
Нийт дүн	0.0	196.1	

ТОДРУУЛГА 25. БУСАД ЗАРДАЛ

		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Бусад зардал		34,738.5	
Нийт дүн		34,738.5	

ТОДРУУЛГА 26. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Тайлант хугацааны ОАТЗ		66,637.6	
Хойшлуулсан орлогын ОАТЗ		(76,223.2)	
Нийт дүн	0.0	(9,585.6)	

1. АУДИТОРЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Бид Иншүрко даатгал ХХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан, аргачлал, заавар журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд алдаагүй үнэн, зөв илэрхийлж гаргасан байна гэж үзээд өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

2. ӨМНӨХ АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Тайлант онд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авч ажилласан байна.

3. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус даатгалын байгууллага нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөртэй холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.

4. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ГҮЙЛГЭЭ

НББОУС 24 Холбоотой талын тодруулгын дагуу холбоотой талууд гэдэг нь нэг тал нөгөө талдаа тодорхой нөлөө үзүүлэх эсвэл санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад нь нөлөөлдөг байхыг хэлнэ. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын 1,200.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийгдсэн байна.

5. ТАЙЛАГНАЛЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Тухайн даатгалын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг бэлтгэж, гаргасан тайлагналын өдрөөс хойш аудитын дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд уг санхүүгийн тайланд нөлөөлөхүйц материаллаг дүн бүхий ажил гүйлгээ гараагүй бөгөөд нөлөө бүхий шийдвэр болон томоохон үйл явдал тохиолдоогүй.